



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/508

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Ойн зурвас, ойжуулалтын талбайд нөхөн сэргээлт, арчилгаа, хамгаалалтын ажил хийх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шалгарсан “Хөвөнтөн-Ой” ХХК-тай 104 998 800 (зуун дөрвөн сая есөн зуун ерэн найман мянга найман зуун) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д олгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Хөвөнтөн-Ой” ХХК-ийн захирал (Ч.Оюун)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010869

Аймгийн Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 17-ны өдрийн
А/508 дугаар захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	А.Гантөмөр